

## Ураг төрөл хэмээх нэр томъёоны тодорхойлолт ба хандлага

Гулсан ХАТУН\*  
Орчуулсан: МӨНХНАРАН Ооёо\*\*  
Монгол Улс, Улаанбаатар,  
Шинжлэх Ухааны Академи,  
Хэл зохиолын хүрээлэн,  
Хэрэглээний хэл шинжлэлийн салбар

### 1. Удиртгал

“Ураг төрөл” хэмээх нэр томъёо нь хэд хэдэн зүйлийг тодорхойлж ирсэн бөгөөд хэрэглэх нөхцөл байдал төвөгтэй учир судлахын тулд илүү хялбарчлах шаардлагатай болдог. “Ураг төрлийн харилцаа” нь цөөнгүй тайлбартай байдаг ч тэдгээрийг аналитик байдлаар тусгаарлан шинжилнэ. Биологийн референт, зан байдлын референт, хэл шинжлэлийн референт гэж байна. Толь бичигт тодорхойлсноор ураг төрөл гэдэг нь цусан төрлийн эсвэл гэрлэлтээс бий болсон ойр дотно харилцааг хэлдэг.

Бүх соёл иргэншилд ойр дотны хүмүүсийг ураг төрөл (цусан холбоот) болон садан төрөл (гэрлэлтээр холбогдсон) хэмээн ангилан ялгах бөгөөд эдгээр ангилалд хамаарах эрх, үүргийн тогтсон хэв маяг нь нийгмийн антропологичдын “ураг төрлийн тогтолцоо” хэмээх нэр томъёог бүрдүүлдэг. Зарим нийгэмд хүн бүр бусад бүх хүнтэйгээ цусан төрөл эсвэл садан төрөл гэдгээрээ ямар нэг байдлаар холбоотой гэж үздэг, эсвэл тэгж боддог бол; харин ихэнх барууны нийгэмд хүний ураг төрөл, худ садан төрөл нь практик утгаараа цөөн хэдэн ойрын хамаатнаар хязгаарлагддаг. Гэсэн хэдий ч нийгэм бүрд төрөл садан, худ урагтай холбоотой зарим харилцаа соёлын хувьд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

Биологийн хувьд зөвхөн хүн төдийгүй бүх амьтад “ураг төрөл”-тэй байдаг. Харин хамгийн чухал нь бусад амьтдаас ялгаатайгаар хүн төрөлхтөн ураг төрлийн ангиллуудыг ухамсартай, ил тод ашиглан нийгмийн харилцааг тодорхойлдог явдал юм.

\* © Gulsan Khatoon, 2020.

Email: [munkhnarano@mas.ac.mn](mailto:munkhnarano@mas.ac.mn)  <https://orcid.org/0000-0001-6083-1445>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

## 2. Ураг төрлийн судалгааны түүх

Ураг төрлийн тогтолцооны тухай шинжлэх ухааны судалгаа нь дөнгөж зуу илүү жилийн түүхтэй боловч энэ богино хугацаанд хүний нийгмийн олон асуудлаас онолын олон нэр томъёоллыг бий болгожээ. Эрт үеийн судалгаанууд нь бүлгийн гэрлэлт, бэлгийн харилцаа дээр суурилсан нийгмийн эхэн үе шатуудын оршин тогтнолыг судлахдаа голлон нэр томъёоны системд илүү анхаарал хандуулж байсан. Антропологич Луис Хенри Морган (Lewis Henry Morgan) бол ураг төрөл судлалыг үндэслэгч бөгөөд тэрээр АНУ-ын зүүн хойд хэсэгт орших Ирокез (Iroquois) уугуул иргэдийг судлахдаа нийгмийг хамтаар нь хамгаалдаг зүйл юу болохыг ихэд сонирхсон байна. Тэрээр “Хүний гэр бүлийн цусан төрөл болон төрөл садны тогтолцоо” хэмээх номондоо ураг төрлийн системийн өөр хэлбэрүүд оршдог гэдгийг анх тунхагласан юм. Английн эрдэмтэн Рэдклифф Браун (Radcliff Brown) нь ураг төрлийн судалгааг шинэ шатанд гаргаж харьцуулах аргыг бий болгосон байдаг. Эванс Притчардын (Evans Pritchard) хийсэн Нуэр хүмүүсийн судалгаа нь ураг төрөлд улс төрийн байгууллага чухал ач холбогдолтойг харуулсан. Фортис (Fortes) Гана улсын Таинси хүмүүсийн дунд хийсэн “Гэр бүлийн динамик”-ийн судалгаагаар удам угсааны бүлгүүдийг нарийвчлан авч үзсэн. Г.П.Мердокийн (G.P. Murdock) “нийгмийн бүтэц” болон Леви-Строссын “Ураг төрлийн анхны бүтэц” зэрэг ураг төрөл судлалын сонгодог бүтээлүүд гарсан байдаг.

### Утга ба тодорхойлолт

Ураг төрлийн судалгаа нь нэр томъёог ашиглан хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийг нийгмийн бүлэг, үүрэг, ангилал болон угсаа гарлын хүрээнд зохион байгуулах зарчим юм. Өөрөөр хэлбэл, ураг төрөл нь харилцааг тооцоолон тодорхойлох арга хэлбэрийг илэрхийлж байна.

Аливаа нийгэмд хэвийн насанд хүрсэн хүн бүр хоёр өөр цөм гэр бүлийн гишүүнд хамаарна. Тухайн хүний төрж өссөн гэр бүлийг “чиг баримжааны гэр бүл” (family of orientation) гэж нэрлэдэг. Харин гэрлэлтээр үүссэн гэр бүлийг “удмын гэр бүл” (family of procreation) гэж нэрлэнэ. Хүн бүр энэхүү хоёр цөм гэр бүлийн гишүүн байх нийтлэг бодит байдал нь ураг төрлийн тогтолцоог бий болгодог. Нэрнээсээ харахад энэ нь хувь хүмүүсийг хооронд нь нарийн төвөгтэй, харилцан уялдсан олон салаа холбоосоор нэгтгэсэн янз бүрийн харилцааны тогтолцоо юм.

- Клод Леви-Стросс “Ураг төрөл болон түүнтэй холбоотой ойлголтууд нь тэдгээрийг хамааруулж ойлгодог биологийн харилцаанаас цаг хугацаанаас эрт, бас түүнээс ангид оршдог”.
- Л.Х.Морган ураг төрлийн нэр томъёог “гэрлэлтийн хэлбэр болон түүнтэй холбоотойгоор гэр бүлийн бүтцийг тусгасан ойлголт” хэмээн тодорхойлсон байдаг (1871).
- А.Р.Радклифф-Браун (1952-) “Ураг төрлийн нэр томъёо нь хүмүүс хоорондын харилцаа, ёс зүйн чиглүүлэгч шинжтэй байх бөгөөд үүнд

харилцан тохирсон эрх, үүрэг, давуу эрх, хариуцлага багтааж байдаг” гэж үзжээ.

- МакЛеннан ураг төрлийн нэр томъёо нь зөвхөн ангиллын хэлбэрүүд бөгөөд цусан холбоо огтхон ч заавал хамааралтай биш гэж үзсэн байна.
- Ж. Битти “Ураг төрөл нь удам гарлын харилцааны цогц биш, харин нийгмийн харилцааны цогц юм” гэж үзжээ.

### 3. Ураг төрлийн хандлага

Ураг төрлийн тогтолцооны талаар цогц ойлголт авах хоёр төрлийн хандлага хэрэгтэй. Нэгдүгээрт, ураг төрлийн үүрэг, бүтцийг тодорхойлон гаргах. Хоёрдугаарт, тухайн бүтэц болон үүрэг бүртэй холбоотой зан үйл, харилцааг судалж, улмаар тэрхүү бүтцийн үүрэг, ач холбогдлыг ойлгох шаардлагатай.

#### Ураг төрлийн үүргийн бүтэц

Ураг төрлийн холбоо нь янз бүрийн хүмүүсийг хамарч, харилцан холбоотой хүмүүсийн бүлгийг нэгэн нэгдэл мэтээр авч үзнэ. Хэдийгээр энэ нь бие даасан нийгмийн бүлэг биш боловч бүлэглэл болон институцийн шинжийг зэрэгцүүлэн агуулдаг. Ураг төрлийн үүрэг, байр суурийн бүтэц нь зөвхөн харилцааны төрлүүдийг илрүүлэхээс гадна тухайн нийгэмд хэрэглэгддэг ураг төрлийн тодорхой нэр томъёонуудыг ч харуулдаг. Харилцааны төрлөөс нь хамааран төрөл садныг үндсэндээ хоёр бүлэгт хуваадаг.

1. Бодит буюу жинхэнэ ураг төрөл
2. Хиймэл буюу зохиомол төрөл садан

“Хиймэл ураг төрөл” хэмээх нэр томъёо нь ёслолын ураг төрөл болон нийгмийн төрөл садныг илэрхийлдэг бөгөөд ёслолоор тогтоогдсон, эсвэл нийгмийн харилцааны үр дүнд бий болсон төрөл садны харилцааг хэлнэ. Харин жинхэнэ ураг төрөл гэдэг нь цусан холбоо эсвэл гэрлэлтээр дамжин бий болсон, сайтар зохион байгуулалттай харилцаа юм.

Хоорондоо цусан холбоотой ураг төрлийг цусан төрөл (consanguineal kin) гэж нэрлэнэ. Харин гэрлэлтээс үүдэн тогтсон төрөл садны харилцааг худ ураг (affinal kin) гэж нэрлэдэг. Жишээлбэл, нэг гэр бүлийн хүрээнд эхнэр, нөхрийн хоорондын харилцаа нь худ ургийн төрөл саданд хамаарах бол эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа нь цусан төрлийн төрөлд хамаарна. Үрчлэн авсан хүүхдийг биологийн хувьд төрсөн үр хүүхэдтэй адилтган үздэг тул түүнийг мөн цусан төрөл саданд хамруулна. Ерөнхийдөө төрөл садны харилцааг эго буюу тухайн хүний байр сууриас эхлэн тодорхойлдог.

Бүх хүн ураг төрлийн статусын нэр томъёог тодорхойлсон эго – амь биетэй харилцан хамааралтай байдаг. Эцэг хүн нь хүүхдийн хувьд анхдагч цусан төрөл садан бол, эх нь эцэгтэй нь зохиомол садан болно. Анхдагч төрөл садангаар эго – амь биетэй холбогдсон хүнийг хоёрдогч төрөл садан гэж хэлнэ. Эцгийн эцэг, эцгийн эгч, эхийн эх, эхнэрийн эх, ахын эхнэр, эгчийн хүү зэрэг нь эго – амь биесийн

хоёрдогч садан төрөл юм. Хоёрдогч төрөл садангууд нь холбоо хэлхээнийхээ шинжээр хоёрдогч цусан төрөл болон хоёрдогч зохиомол садан төрөлд багтана. Тийм маягаар хоёрдогч төрөл садны анхдагч хамаатан садангууд нь ego – амь биеийн гуравдагч төрөл садангууд болдог. Жишээлбэл, эцгийн эгчийн нөхөр, эхнэрийн ахын хүү, охины нөхрийн эгч зэрэг хүмүүс нь энэхүү гуравдагч төрөл садангийн бүлэгт багтана. Гуравдагч төрөл төрөгсдөөс илүү алслагдсан харилцааг холын хамаатан садан гэж тодорхойлдог. Цусан төрөл болон зохиомол төрөл садны харилцааг анхдагч, хоёрдогч болон гуравдагч төрөл садан гэж ангилах бөгөөд холын хамаатныг энэхүү харилцааны ойрын зэрэглэлтэй гэж үзэж болно.

#### 4. Ураг төрлийн нэр томьёо

Ураг төрлийн нэр томьёог нийгэм доторх зүйл бүрийн төрөл садныг тодорхойлоход хэрэглэдэг. Хувь хүний нэр байх хэдий ч бүх нийгэм тодорхой ураг төрлийн нэр томьёог хамаатан садны дотор өргөн хүрээнд ашигладаг. Ураг төрлийн нэр томьёо болон хувь хүний нэрийн хооронд завсрын хэлбэр гэж бас байдаг. Үүнийг *teknonymy* буюу эцэг эхийг нь хүүхдийн нэрээр дуудах гэж нэрлэдэг. Жишээлбэл, хүү, охинтой хүнийг ихэвчлэн “\_\_\_ (хүүхдийн нэр)”-ийн эцэг, \_\_\_ (хүүхдийн нэр) эх” гэж дууддаг. Энэ нь тухайн хүний овог нэр эсвэл ураг төрлийн нэр томьёоны оронд эцэг эхийн нэр болон хүүхдийн нэрний нэгдэл юм. Иймэрхүү нэр томьёо нь заримдаа нийгмийн үзэгдлийг тусгаж буй учраас чухал ач холбогдолтой юм. Ураг төрлийн нэршлийн (*nomenclature*) судалгаанд өдгөө ч чухал ач холбогдолтой арга зүйг Морган (*Lewis Henry Morgan*) дэлхийн өнцөг булан бүрээс олон янзын ураг төрлийн өөр өөр нэр томьёог бүртгэн гаргасан билээ. Тэрээр ураг төрлийн нэр томьёог хоёр үндсэн бүлэгт хуваасан. Ингээд тэднийгээ ангилах ураг төрлийн систем болон тодорхойлох ураг төрлийн систем гэж нэрлэжээ.

- *Ангилх ураг төрлийн систем*: Бүх хамаатан садныг хатуу логикийн дагуу ангилдаг. Бүгдийг нь ижил овог нэрээр нэрлэдэг.
- *Тодорхойлох ураг төрлийн систем*: Төрөл садан бүрд тусдаа нэр томьёотой байдаг бөгөөд ийм нэр томьёо нь тухайн төрөл садангуудын эго-ийн тодорхой хамаарлыг илэрхийлдэг.

Бодит байдал дээр “ангилах” ба “тодорхойлох” гэсэн үг нь нэр томьёоны бүхэл тогтолцоонд бус зөвхөн ураг төрлийн нэр томьёонд илүү хамаатай юм.

Г.П.Мёрдок дэлхийн хэмжээнд нэр томьёоны зургаан үндсэн системийг тодорхойлсон. Тэдгээр нь дараах байдалтай байна.

- Эскимос систем
- Хавай систем
- Ирокез систем
- Омаха систем
- Кроу систем
- Судан систем

Мердок ураг төрлийн талаар хийсэн нарийвчилсан судалгаандаа ураг төрлийн нэр томъёог ойлгох өргөн хүрээтэй, нарийн тогтолцоог дэвшүүлсэн байдаг. Түүний үзэж байгаагаар ураг төрлийн нэр томъёог техникийн хувьд гурван өөр аргаар ангилж болно:

- *Хэрэглээний хэлбэрээр (By the mode of use)*

Хэрэглээний хэлбэрт үндэслэн ураг садны нэр томъёог хоёр хэсэгт хуваадаг. Зарим нэр томъёо нь шууд хандаж дуудах зориулалттай байдаг бол зарим нь дам байдлаар ялгах зориулалттай байдаг. “Хаягласан нэр томъёо” (term of address) нь ураг төрлөө шууд дуудахад хэрэглэгддэг бол “лавлагааны нэр томъёо” (term of reference) нь гуравдагч этгээдэд тухайн хүний тухай ярих үед ашиглагддаг.

- *Хэлзүйн бүтцээр (By the linguistic structure)*

Хэлзүйн бүтцээр нь ангилбал ураг садны нэр томъёог энгийн, уламжлалт хэмээн ялгана. Энгийн нэр томъёо (elementary term) нь англи хэлний father, nephew зэрэг задлан шинжлэх боломжгүй, өөрөөр хэлбэл ураг төрлийн утга бүхий бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваагддаггүй үгсийг хэлнэ. Иймээс тэдгээрийг “энгийн” гэж нэрлэдэг. Харин уламжлалт нэр томъёо нь хоёр болон түүнээс олон энгийн нэр томъёог нэгтгэсэн тодорхой нэг төрөл садны харилцааг илэрхийлдэг. Жишээлбэл: өвөө (grandfather), хадам эцэг (father-in-law), дагавар охин (stepdaughter) зэрэг юм.

- *Хэрэглээний хүрээгээр (By the range of application)*

Энэ шалгуураар ураг төрлийн нэр томъёог тодорхойлогч (denotative term) болон ангилсан (classificatory term) гэж хоёр хуваана. Тодорхойлогч нэр томъёо нь үе, хүйс, удам гарлын холбоогоор тодорхойлогдсон нэг л төрлийн ураг төрөлд хэрэглэгддэг. Жишээлбэл, англи хэлний brother, sister, daughter, son-in-law зэрэг нь ижил нэршлээр хэд хэдэн хүнийг илэрхийлж болох ч нэг төрлийн харилцааг заана. Үүний эсрэгээр ангилсан нэр томъёо нь хоёр болон түүнээс олон өөр төрөл садны ангилалд хамаарах хүмүүст хэрэглэгддэг. Тухайлбал, англи хэлний grandmother буюу өвөө гэдэг нь эхийн эх болон эцгийн эх хоёуланг нь илэрхийлнэ. Мөн авга ах - uncle гэдэг нэр томъёо нь эцэг эхийн аль нэгийн ах дүү, эсвэл эцгийн эгч, эхийн эгчийн нөхрийг ч зааж болдог.

## 5. Ураг төрлийн зан үйл

Ураг төрлийн судалгаа нь ураг төрлийн тайлбар, тэдгээрийг ангилах, эсвэл ураг төрлийн зан үйлийн ерөнхий хэлбэрүүдээр хязгаарлагддаггүй. Ялангуяа бичиг үсэггүй нийгэмд онцгой ач холбогдол бүхий ураг төрлийн зарим зан үйлүүд гэж байдаг.

- *Авункулам (Avunculate)*

Энэ нь эхийн ах (нагац) болон түүний эгчийн хүүхдүүдийн хооронд илэрдэг өвөрмөц зан үйл юм. Зарим эхийн эрхэт нийгэмд нагац ах нь эцгийн үүргийг орлон гүйцэтгэдэг. Зээ хүү, зээ охин нь түүний халамжинд байж, өмч хөрөнгийг

нь өвлөдөг. Ийм төрлийн харилцаа Меланезийн Тробриандын арлуудын оршин суугчид, Фижичүүд, Африкийн зарим овог аймаг болон Өмнөд Энэтхэгийн Найр нарт ажиглагддаг.

- *Амитайм (Amitate)*

Ийм төрлийн зан үйл нь авункулаттай төстэй боловч эцгийн эрхэт нийгэмд түгээмэл байдаг. Авга эгч нь өндөр хүндлэл хүлээж, чухал байр суурь эзэлдэг. Тэрээр зээ хүүдээ ээжээс ч илүү нөлөөтэй байж, амьдралын олон үйл явдалд эрх мэдэлтэй байдаг. Үнэндээ энэ нь хадмын гэрээс хөөгдөх, хаягдах зэрэг тохиолдолд авга эгч нарыг үл тоомсорлогдохоос хамгаалсан нийгмийн механизм юм. Полинезийн Тонга, Өмнөд Энэтхэгийн Тода зэрэг нийгэмд ийм төрлийн ураг төрлийн хэрэглээ байдаг.

- *Кувад (Couvade)*

Эхнэр, нөхрийн хооронд илэрдэг ураг төрлийн өвөрмөц зан үйл юм. Энэтхэгийн Тода, Хаси овог аймгуудыг жишээ болгон дурдаж болно. Эхнэр нь хүүхэд төрүүлэх үед нөхөр нь ч мөн адил хатуу дэглэм баримталж, тусгай хоолны дэглэм сахих зэрэг олон төрлийн цээрийг хамт мөрдөх үүрэгтэй. Антропологичид кувадыг эцэг болох бэлгэдлийг баталгаажуулж буй зан үйл гэж үздэг. Ийм зан үйл Өмнөд Энэтхэгийн Найр, Японы Айнү, мөн Хятадын зарим нийгэмд түгээмэл байжээ.

- *Зайлсхийх харилцаа (Avoidance)*

Ихэнх нийгэмд зайлсхийх харилцаа нь ойрын төрлийн хүмүүсийн хоорондын бэлгийн харилцаа бий болохоос сэргийлэх үүрэгтэй. Уламжлалт нийгмийн хэм хэмжээний дагуу хадам аав нь бэрээсээ зайлсхийдэг. Мөн хадам эх, авга ах болон бэр дүү нарын хооронд ийм төрлийн харилцаа ажиглагдана. Энэ нь өдөр тутам нүүр тулан харилцдаг ойрын төрөл садны дунд бэлгийн зохисгүй харилцаа үүсэхээс хамгаалах арга хэмжээ юм.

- *Хошин харилцаа (Joking Relationship)*

Энэ нь зайлсхийх харилцааны яг эсрэг хэлбэр юм. Ийм харилцаанд оролцогчид бие биенээ янз бүрийн тоглоом, тэр дундаа заримдаа бүдүүлэг, завхай хошигнолоор шоглон сорьдог. Ихэвчлэн ийм харилцаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрсдийн хадам дүү нар (эсрэг хүйсний), үеэлүүдийн хооронд оршдог. Тоглоомтой харилцаа нь овгийн нийгэмд ялангуяа Хиндү нийгэмд ч ажиглагддаг.

Антропологичид нийгэмд ураг төрлийн нэр томьёо нь чухал үүрэг гүйцэтгэдэг төдийгүй өөрчлөлтөд тэсвэртэй тогтвортой шинж чанартай байдаг гэж үздэг. Эдгээр нэр томьёо нь зөвхөн ураг төрлийг ялган танихад төдийгүй гэр бүлийн хэлбэр, дүрэм, удам угсааны болон нийгмийн тогтолцооны бусад олон чухал шинжийг илэрхийлдэг.

## 6. Удам угсааны дүрэм (Rules of Descent)

Ихэнх нийгэмд ураг төрлийн холбоо маш чухал ач холбогдолтой байдаг. Хүн бүр өөрийн ураг төрлийн өмнө тодорхой үүрэг хүлээдэг бөгөөд мөн адил тэднээсээ үүрэг, хариуцлага нэхэж байдаг. Хувь хүнийг тодорхой, ялгагдахуйц ураг төрлийн бүлэгт хамааруулдаг дүрмийг удам угсааны дүрэм гэж нэрлэдэг. Эдгээр дүрэм нь нийгэм бүрд харилцан адилгүй байдаг. Өв залгамжлал болон өв хөрөнгийн шилжилт нь ураг төрлийн дүрэмтэй шууд холбоотой. “Өв залгамжлал” (succession) гэдэг нь эрх мэдэл, байр суурь шилжүүлэхийг, харин “өв хөрөнгө” (inheritance) гэдэг нь эцэг эхийн өмч хөрөнгийг эзэмших эрхийг илэрхийлнэ. Ихэвчлэн энэ хоёр эрх хамт хэрэгждэг.

Ураг төрлийн дараах үндсэн дүрмүүдийг ялган тодорхойлдог.

- Нэг шугамт удам угсаа (Unilineal Descent)  
Удам угсааг эцгийн эсвэл эхийн аль нэг шугамаар тогтоох зарчим.
- Эцгийн шугамт удам угсаа (Patrilineal Descent / Agnatic)  
Энэ тохиолдолд удам угсаа нь эрэгтэй шугамаар, өөрөөр хэлбэл өвөг дээдсээс хүү, ач хүү, гуч хүү гэх мэт эрэгтэй талаар дамжин тогтоогдоно. Эрэгтэйчүүд давамгайл байр суурь, эрх мэдэл, өмч хөрөнгийг эзэмшинэ. Энэ тогтолцоо Зүүн ба Өмнөд Ази, Ойрх Дорнодын орнуудад түгээмэл.
- Эхийн шугамт удам угсаа (Matrilineal Descent / Uterine)  
Эхийн шугамаар, өөрөөр хэлбэл эх, охин, ач охин, жич охин гэх мэт эмэгтэй холбоосоор дамжин удам угсааг тогтооно.
- Давхар удам угсаа (Double Descent)  
Нэг нийгэмд хоёр өөр нийгмийн бүлэг, ангилал зэрэгцэн оршдог тогтолцоо бөгөөд нэг нь эцгийн тал, нөгөө нь эхийн талын угсаанд тулгуурладаг. Эдгээрийг өөр өөр зорилгоор ашигладаг. Жишээлбэл, Нигерийн Яко ард түмний дунд ийм тогтолцоо бий.
- Когнатик удам угсаа (Cognatic Descent)  
Удам угсааг эрэгтэй, эмэгтэй аль ч холбоосоор, эсвэл тэдгээрийн аль ч хослолоор тогтоодог хоёр талт удмын тогтолцоо юм.
- Хоёр талт удам угсаа (Bilateral Descent)  
Удам угсааг эцэг болон эх хоёулангийн шугамаар тогтоодог зарчим. Хоёр талт удамшлын тогтолцооны үед овгийн нэг гишүүн бүр эцгийн болон эхийн хоёр овогт харьяалагддаг. Жишээлбэл, Химба угсаатны дунд овгуудыг тухайн овгийн хамгийн ахмад эрэгтэй удирддаг.
- Сонгомол удам угсаа (Ambilineal Descent)  
Удам угсааг эрэгтэй эсвэл эмэгтэй шугамаар, тодорхой тогтсон дараалалгүйгээр тогтоодог зарчим юм.

## 7. Удам угсааны бүлэг (Descent Group)

Удам угсааны бүлэг гэж гишүүд нь өөрсдийгөө нэгэн нийтлэг өвөг дээдсээс гаралтай хэмээн үзэж, тийнхүү ярьж ойлгодог нийгмийн бүлгийг хэлнэ.

### *Удам угсаа (Lineage)*

Нэг шугамт удам угсааны (unilineal descent) дагуу бүрэлдэн тогтсон цусан төрлийн бүлгийг техникийн хувьд удам угсаа гэж нэрлэдэг. Энэ бүлгийн гишүүд нь тухайн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн удамшлын шугамаар, тодорхой санагдаж буй удам гарлын холбоосоор дамжуулан өөрсдийн нийтлэг гарал үүслийг бодитоор тогтоодог. Ихэвчлэн удам угсаа нь дараалсан 5–6 үеийн өвөг дээдсийг хамаарна.

Удам угсаа нь эцгийн шугамт удам угсаа (patrilineage) болон эхийн шугамт удам угсаа (matrilineage) гэсэн хоёр төрөлтэй. Удам угсаа нь заавал экзогам буюу дотроо гэрлэхийг хориглодог. Энэ нь төрөлт, нас баралттай холбоотой ариун хийгээд бузарын тухай ойлголтыг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Удам угсааны бүх гишүүд сэтгэлзүйн нэгдмэл байдлыг бүрдүүлж оршдог. Мөн удам угсаа нь гишүүддээ нийгмийн баталгаа болдог, ялангуяа хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн салбарт хамтран ажиллана. Хямрал, бэрхшээлийн үед удам угсааны гишүүд нэгдэн харилцан тусалдаг.

### *Овог аймаг (Clan)*

Овог аймаг нь удам угсаанаас илүү том нэг шугамт төрөл садны бүлэг юм. Энд гишүүд өөрсдийгөө нэг өвөг дээдсээс гаралтай гэж үздэг боловч удам угсааг хэт нарийвчлан тогтоодоггүй. Овгууд нь мөн экзогам шинжтэй байдаг. Үүнийг эцгийн эрхэт, эхийн эрхэт, өвөг дээдсийн, тотемын, нутаг дэвсгэрийн овог аймаг зэрэг төрлүүдэд ангилж болно.

### *Фратри (Phratry)*

Хоёр болон түүнээс олон овог аймгуудын нэгдлийг фратри гэнэ. Иймээс фратри нь овог аймгаас том нэг шугамт угсааны бүлэг юм. Фратри нь экзогам байж болох ч заавал тийм байх албагүй. Жишээлбэл, Кроу индианчуудын 13 овог аймаг 6 нэргүй фратрид хуваагддаг бөгөөд тэдгээрийн 4 нь гэрлэлтийн дүрмийг хатуу мөрддөггүй.

### *Моэти (Moiety)*

Моэти нь угсаа гарвалын үндсэн дээр нийгмийг хоёр хагас болгон хувааснаар бий болдог, хамгийн том нэг шугамт нийгмийн бүлэг юм. Moiety гэдэг үг нь франц хэлний “хагас” гэсэн утгатай үгнээс гаралтай. Моэти нь экзогам эсвэл эндогам аль аль нь байж болно. Экзогами гэдэг нь тухайн бүлгээсээ гадуур гэрлэхийг нийгмийн хувьд зөвшөөрсөн гэрлэлтийн зохион байгуулалт юм. Үүний эсрэг ойлголт нь эндогами, өөрөөр хэлбэл өөрийн бүлгийн дотор гэрлэх явдал юм.

Бибстериин тодорхойлсноор, овог аймаг гэдэг нь толгойлогчид нь нэг нийтлэг өвөг дээдсээс гаралтай гэж үздэг хэд хэдэн өрхөөс бүрдсэн нийгмийн бүлэг юм (G. P. Murdock, Social Structure). Хамтын зохион байгуулалт, хамтарсан үйл ажиллагаа, бүлгийн чиг үүрэгтэй байх нь овог аймгийн гол онцлог шинж юм.



### Антропологи дахь ураг төрлийн онцлог шинж

Антропологид ураг төрөл гэдэг нь ихэнх нийгэмд, олонх хүмүүсийн амьдралын чухал хэсгийг бүрдүүлдэг нийгмийн харилцааны өргөн сүлжээ юм. Гэхдээ энэ ойлголтын нарийн утга, агуулга нь тухайн шинжлэх ухааны салбарын хүрээнд өдгөө ч маргаантай хэвээр байдаг. Антропологич Робин Фокс “ураг төрлийн судалгаа гэдэг нь хүний амьдралын үндсэн бодит нөхцөлүүд болох гэрлэх, жирэмслэлт, эцэг эх болох, нийгэмших, ах дүүсийн харилцаа зэрэгт хүн юу хийдгийг судлах явдал юм” хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэрээр хүний нийгэм нь өвөрмөц онцлогтой гэж үздэг. Учир нь хүн төрөлхтөн амьтны ертөнцөд байдагтай ижилхэн удам гарлыг чухалчилдаг ч түүнийг ухамсартайгаар ойлгон ангилж, нийгмийн зорилгодоо нийцүүлэн ашиглаж чаддаг. Эдгээр нийгмийн зорилгод хүүхдийг нийгэмшүүлэх, эдийн засаг, улс төр, шашны үндсэн бүлгүүдийг бүрдүүлэх зэрэг орно. Ураг төрөл нь улс төр, шашин, эдийн засгийн талтай нягт холбоотой учраас антропологичдын сонирхлыг гойд татдаг. Мөн хүмүүс өөрсдийн ураг төрлийн харилцааны загварыг хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаагаас тухайн нийгмийн бүтэц, харилцааны динамикийг танин мэдэх боломжтой байдаг.

Ураг төрөл нь бие даасан, өвөрмөц судлагдахуун байдаг. Тухайн нийгэмд ураг төрөл нь нийгмийн нэгж бүрийн үүрэг, чиг үүргийг тодорхойлдог. Мөн ураг төрлийн харилцаа бүх нийтийг хамардаг тул өөр өөр нийгэмд түүний бүтцийн ялгаатай байдлыг судлах нь сонирхол төрүүлдэг. Нийгэм нь хүмүүсийг янз бүрийн зарчимд үндэслэн ангилж, байр суурь олгодог бөгөөд эдгээрийн хамгийн чухал зарчим нь ураг төрөл юм.

Нелсон болон Грабнер нарын Reading in Kinship and Social Structure бүтээлд нийгмийг судлахад ураг төрлийн ач холбогдлыг дараах байдлаар онцолсон байдаг.

- Ураг төрлийн тогтолцоо нь бүх нийтийн шинжтэй.
- Ураг төрлийн тогтолцоо нь бүх хүний нийгмийн бүтцэд (ялгаатай хэмжээнд ч болов) үргэлж чухал байр суурь эзэлдэг.
- Антропологичдын уламжлалт судалж ирсэн ихэнх нийгэмд ураг төрөл нь зохион байгуулалтын гол зарчмуудын нэг байсаар ирсэн.
- Ураг төрлийн тогтолцоог тодорхойлоход харьцангуй хялбар энгийн шинжилгээ тохиромжтой байдаг.

### Дүгнэлт

Ураг төрөл нь ураг төрлийн нэр томъёог ашиглан хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийг нийгмийн бүлэг, үүрэг, ангилал болон удам гарлын хүрээнд зохион байгуулах зарчим юм. Өөрөөр хэлбэл, ураг төрөл нь харилцааг тооцоолон тодорхойлох арга хэлбэрийг илэрхийлнэ. Аливаа нийгэмд хэвийн насанд хүрсэн хүн бүр хоёр өөр цөм гэр бүлийн гишүүн байдаг. Тухайн хүний төрж өссөн гэр бүлийг “чиг баримжааны гэр бүл” (family of orientation) гэж нэрлэдэг. Харин гэрлэлтээр дамжин харилцаа тогтоосон нөгөө гэр бүлийг “удмын гэр бүл” (family of procreation) гэдэг. Хүн

бүр энэ хоёр цөм гэр бүлийн гишүүн байх нийтлэг бодит байдал нь ураг төрлийн тогтолцоог бий болгодог. Нэрнээсээ харахад энэ нь хувь хүмүүсийг хооронд нь нарийн төвөгтэй, харилцан уялдсан олон салаа холбоосоор нэгтгэсэн янз бүрийн харилцааны тогтолцоо юм.

Ураг төрлийн тогтолцооны шинжлэх ухааны судалгаа дөнгөж зуу орчим жилийн түүхтэй боловч энэ богино хугацаанд хүний нийгмийн бусад олон асуудлаас илүү маргаан, олон янзын онолын тайлбаруудыг төрүүлсэн байдаг. Эхэн үеийн судалгаанууд голчлон ураг төрлийн нэр томъёоны тогтолцоонд анхаарч, тэдгээрийг түүхэн харилцааны нотолгоо болгон ашиглах, эсвэл бэлгийн харилцаа, бүлгийн гэрлэлтэд суурилсан нийгмийн өмнөх үе шатны үлдэц хэмээн тайлбарлаж байв. Антропологич Льюис Хенри Морганыг ураг төрлийн судалгааг үндэслэгч гэж тооцогддог. Тэрээр АНУ-ын зүүн хойд нутгийн уугуул америкчууд болох Ирокезуудыг судалж, нийгмийг юу нэгтгэж, тогтоон барьж байдгийг сонирхож байв. Тэрээр “Хүний гэр бүлийн цусан төрөл болон төрөл садны тогтолцоо” хэмээх бүтээлдээ ураг төрлийн тогтолцооны янз бүрийн хэлбэрүүдийг анхлан тодорхойлсон. Английн эрдэмтэн Радклифф-Браун харьцуулсан аргыг нэвтрүүлснээр ураг төрлийн судалгааг шинэ шатанд гаргасан. Эванс-Притчард Нуэр ард түмнийг судалснаар ураг төрлийг улс төрийн зохион байгуулалтад гүйцэтгэх үүргийг тодруулсан. Фортес Ганагийн Тайленси ард түмний дунд хийсэн “Кланы динамик” судалгаагаараа ураг төрлийн бүлгүүдийг нарийвчлан авч үзсэн. Мөн Г. П. Мердокийн “Нийгмийн бүтэц”, Леви-Строссын “Ураг төрлийн анхдагч бүрдэлүүд” зэрэг бүтээлүүд нь ураг төрлийн судалгааны сонгодог зохиолууд юм.

Ураг төрлийн тогтолцоог цогцоор нь ойлгохын тулд хоёр төрлийн хандлага шаардлагатай. Нэгдүгээрт, ураг төрлийн үүрэг, байр суурийн бүтцийг тодорхойлох; хоёрдугаарт, тухайн бүтэц, үүрэг бүртэй холбоотой зан үйл, харилцааг судалж, тэдгээрийн үүргийн ач холбогдлыг ойлгох хэрэгтэй. Ураг төрлийн холбоо нь өргөн хүрээний хүмүүсийг хамарч, хоорондоо холбоотой бүхэл бүтэн хүмүүсийн нэгдлийг илэрхийлдэг. Хэдийгээр энэ нь бие даасан нийгмийн бүлэг биш боловч бүлэглэл болон институцийн шинжийг зэрэгцүүлэн агуулдаг. Ураг төрлийн үүргийн бүтэц нь зөвхөн харилцааны төрлүүдийг илрүүлэхээс гадна тухайн нийгэмд хэрэглэгддэг тодорхой ураг төрлийн нэр томъёонуудыг ч харуулдаг.

Антропологид ураг төрлийг ихэнх нийгэм болон хүмүүсийн амьдралын чухал хэсгийг бүрдүүлдэг нийгмийн харилцааны сүлжээ гэж үздэг. Гэхдээ түүний нарийн утга агуулга нь антропологийн хүрээнд ч маргаантай байна. Антропологич Робин Фокс “ураг төрлийн судалгаа нь хослох, жирэмслэх, эцэг эх болох, нийгэмших, хамаатан садны харилцаа үүсэх зэрэг амьдралын үндсэн бодит нөхцөлүүдэд хүн юу хийдгийг судлах явдал юм” хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэрээр хүний нийгэм нь амьтны ертөнцөд байдагтай ижил боловч ураг төрлийн харилцааг хүмүүс ухамсартайгаар ойлгон ангилж, нийгмийн зорилгодоо нийцүүлэн ашигладагаараа онцлог гэж үзсэн.

Иймээс ураг төрөл нь бие даасан, өвөрмөц судалгааны салбар байх чанартай юм. Тухайн нийгэмд ураг төрөл нь нийгмийн нэгж бүрийн үүргийг тодорхойлдог. Түүнчлэн бүх нийтийг хамарсан шинж чанар нь өөр өөр нийгмийн орчинд түүний бүтцийн ялгаатай байдлыг судлах сонирхлыг төрүүлдэг. Нийгэм нь хүмүүсийг янз бүрийн зарчмаар ангилж, байр суурь олгодог бөгөөд эдгээрийн дундаас хамгийн чухал зарчим нь ураг төрөл юм.